



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 29-адар

Дугаар А/501

Улаанбаатар хот

Г Ерөнхий боловсролын зарим сургуулийн талаар авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” 2021 оны А/35/A/10/9 дүгээр хамтарсан тушаалыг тус тус үндэслэн 2013-2023 онд бага, дунд боловсролын судалгаа, арга зүйн туршилт зохион байгуулсан ерөнхий боловсролын лаборатори (хуучнаар) сургуулийн эрх зүйн байдал өөрчлөгдсөнтэй холбогдуулан Боловсролын ерөнхий хууль, Зөвшөөрлийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 7.7-д заасан ерөнхий боловсролын сургуульд хамааруулан сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хүчин төгөлдөр хугацааг сунгах, сургуулийн нэршлийг өөрчлөх боловсролын сургалтын байгууллагын жагсаалтыг хавсралтаар баталж, 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.

2. Хавсралтад заасан ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалд өмнө нь сонгон шалгаруулалтын үр дүнд томилогдсон захирлыг үргэлжлүүлэн томилох, захирлын албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд сонгон шалгаруулалтыг эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу зохион байгуулж томилохыг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Хавсралтад заасан сургуулийн албан хаагчдад Засгийн газрын тогтоолоор өмнө олгогдож байсан нэмэгдлийг батлагдсан төсвийн дагуу 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл олгох, сургалтын хөтөлбөрийн болон технологийн туршилт, төсөл хэрэгжүүлсэн ур чадвар бүхий багш, ажилтанд 2023 оны 3, 4 дүгээр улирлын нэмэгдлийг олгох зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Б.Батцэцэг/-т, Боловсролын ерөнхий газар /Т.Ням-Очир/-т, сургуулийн захирал нарт тус зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газар /А.Цолмон/-т даалгасугай.



САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

Боловсрол, шинжлэх ухааны сайдын  
2023 оны 11. дүгээр сарын 19. нийт өдрийн  
8/501 дүгээр тушаалын хавсралт

СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮЧИН ТӨГӨЛДӨР  
ХУГАЦААГ СУНГАХ, СУРГУУЛИЙН НЭРШЛИЙГ ӨӨРЧЛӨХ БОЛОВСРОЛЫН  
СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

№	Сургалтын байгууллагын нэр
1.	Архангай аймгийн ерөнхий боловсролын лаборатори “Хүмүн” цогцолбор сургууль
2.	Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургууль
3.	Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын лаборатори 3 дугаар сургууль
4.	Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын лаборатори “Номуун далай” цогцолбор сургууль
5.	Булган аймгийн ерөнхий боловсролын лаборатори “Эрдмийн өргөө” цогцолбор сургууль
6.	Булган аймгийн Хишиг Өндөр сумын ерөнхий боловсролын лаборатори сургууль
7.	Говь-Алтай аймгийн ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургууль
8.	Говьсүмбэр аймгийн ерөнхий боловсролын лаборатори 5 дугаар сургууль
9.	Дархан-Уул аймгийн ерөнхий боловсролын лаборатори “Оюуны ирээдүй” цогцолбор сургууль
10.	Дорноговь аймгийн ерөнхий боловсролын лаборатори 2 дугаар сургууль
11.	Дорноговь аймгийн Замын-Үүд сумын ерөнхий боловсролын лаборатори сургууль
12.	Дорнод аймгийн ерөнхий боловсролын лаборатори “Хан-Уул” цогцолбор сургууль
13.	Дундговь аймгийн ерөнхий боловсролын лаборатори “Эрдмийн далай” цогцолбор сургууль
14.	Завхан аймгийн ерөнхий боловсролын лаборатори “Чандмань эрдэнэ” цогцолбор сургууль
15.	Завхан аймгийн Тосонцэнгэл сумын ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургууль
16.	Орхон аймгийн ерөнхий боловсролын лаборатори 8 дугаар сургууль
17.	Өвөрхангай аймгийн ерөнхий боловсролын лаборатори “Мэргэд” сургууль
18.	Өмнөговь аймгийн ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургууль
19.	Сүхбаатар аймгийн ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургууль
20.	Сэлэнгэ аймгийн ерөнхий боловсролын лаборатори 4 дүгээр сургууль
21.	Төв аймгийн ерөнхий боловсролын лаборатори “Хүмүн” цогцолбор сургууль
22.	Увс аймгийн ерөнхий боловсролын лаборатори “Шинэ ирээдүй” цогцолбор сургууль
23.	Ховд аймгийн ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургууль
24.	Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын лаборатори “Эрдмийн далай” сургууль

25.	Хэнтий аймгийн ерөнхий боловсролын лаборатори 1 дүгээр сургууль
26.	Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 12 дугаар сургууль
27.	Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 14 дүгээр сургууль
28.	Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 20 дугаар сургууль
29.	Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 23 дугаар сургууль
30.	Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 28 дугаар сургууль
31.	Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 33 дугаар сургууль
32.	Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 44 дүгээр сургууль
33.	Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 45 дугаар сургууль
34.	Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 71 дүгээр сургууль
35.	Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 93 дугаар сургууль
36.	Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 115 дугаар сургууль
37.	Нийслэлийн Налайх дүүргийн ерөнхий боловсролын лаборатори 119 дүгээр сургууль
38.	Нийслэлийн Багануур дүүргийн ерөнхий боловсролын лаборатори "Боловсрол" цогцолбор сургууль
39.	Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори "Ирээдүй" цогцолбор сургууль
40.	Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори "Эрдмийн өргөө" цогцолбор сургууль
41.	Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори Монгени сургууль
42.	Нийслэлийн өсвөрийн зохион бүтээгчдийн ерөнхий боловсролын лаборатори ахлах сургууль
43.	Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 141 дүгээр сургууль
44.	Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 142 дугаар сургууль
45.	Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 151 дүгээр сургууль

--- оОо ---